

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2019-11-29/**

Ажлын хэсгийн 49 дугаар хуралдаан 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 10.00 цагт Пума Имperiал зочид буудлын 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож Уул уурхайн бодлогын газрын Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга ахлах шинжээч Ч.Цогтбаатар, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Батболдыг орлож ахлах шинжээч А.Пүрэв, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга П.Цогтсайханыг орлож ахлах мэргэжилтэн Б.Буяннэмэх, Ашигт малтмал газрын тосны газрын орлогч дарга М.Энхжаргал, мэргэжилтэн Г.Оюунтуяа, Татварын ерөнхий газрын байцаагч Ж.Батцэнгэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүг орлож байцаагч Ц.Мөнхцэцэг, Нээлттэй Нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэгийг орлож ТАН эвслийн харилцааны мэргэжилтэн Т.Саруул, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ийн ТУЗ-ын гишүүн Д.Сүхбаатарыг орлож гишүүн Баяраа, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Их баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор, Эрхүүгийн улс, ард аж ахуйн дээд сургуулийг төгсөгчдийн холбооны тэргүүн Л.Бямбажав, МБОИЗ-ын удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболдыг орлож туслах Сувдмаа, МБОИЗ-ын гишүүн Н.Эрдэнэсайхан, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Т.Мөнхбатыг орлож мэргэжилтэн Б.Ренчинпагма, Бадрах ХХК-ны Ц.Энхжаргал, Оч, Алт үйлдвэрлэгчдийн холбооны Болдтөмөр, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Саус гоби сэндс ХХК-ийн Засгийн газар олон нийттэй харилцах хэлтсийн дарга Х.Баярмаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 25 гишүүн оролцож, ирц 75,8 хувьтай байв.

Мөн хуралдаанд БДО аудит ХХК-ийн зөвлөх Радхуле, удирдах партнер Г.Баянмөнх, партнер Л.Баярцогзол нар болон бусад аудиторууд, Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн ажилтан Н.Золжаргал, ажлын албаны санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх О.Мөнхбат нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын ахлах шинжээч Ч.Цогтбаатар нээж үг хэлэв.

Ч.Цогтбаатар: Яамны ТНБД-ийн үүргийн дагуу өнөөдрийн ажлын хэсгийн хуралдааныг удирдах үүрэгтэй оролцож байна. Ажлын хэсгийн гишүүд Та бүхэнтэй өнөөдөр уулзаж байгаадаа баяртай байна.

Хэдхэн хоногийн өмнө батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд бидний хэлэлцэж байгаа ил тод байдлын талаар чухал асуудлууд орсон гэдгийг хэлмээр байна. Иргэн эрүүл орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд байгалийн баялагийг ашигласнаар байгаль орчинд учрах нөлөөллийн талаар мэдэх эрхтэй гэсэн чухал асуудлыг Үндсэн хуульд оруулж өгсөн байна. УУХҮЯ, ЕСБХБ болон

Азийн хөгжлийн банкуудтай хэлэлцээр хийж ОУИТБС-ын ажлын албаны санхүүжилтийг шийдвэрлэсэн. ЕСБХБ-тай богино хугацааны гэрээ байгуулж, АХБ-тай 2021 оны 11 дүгээр сар хүртэл хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна, цаашид ажлын алба маань санхүүжилтийн хувьд бэрхшээл гарахгүй гэж найдаж байна. Өнөөдрийн хуралдаанаар ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлангийн төсөл, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөөний төсөл, нэмэлт мэдээллийн маягтад оруулах нэмэлт өөрчлөлт болон Засгийн газрын тогтоолын төслийн талаар хэлэлцэнэ.

Монгол улс ОУИТБС-ын стандартыг хангасан хоёрдахь орноор шалгарсан нь манай улсын нэр хүндийг өргөсөн томоохон үйл явдал болсон төдийгүй олборлох салбарыг хариуцлагатай уул уурхай болгон хөгжүүлэх, талуудын хамтын ажиллагаа сайжирч байгаа нотолсон бодит жишээ болсон. Бидний цаашдын зорилго бол стандартыг хангахад чиглүүлж ажиллах ёстой. Дараагийн баталгаажуулалт 2021 оны 2 дугаар сард болох хэдий ч цаг алдалгүй ажлаа эрчимжүүлээд, стандартаа сайн хангахын төлөө зорьж ажиллах хэрэгтэй байна. Үүнийг хэрэгжүүлэхэд бидэнд боломж нээлттэй байгаа гагцхүү идэвх санаачилга, хамтын ажиллагаа чухал байгаа гэж үзэж байна. Бид зорилтоо биелүүлж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна. Үүний зэрэгцээ ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд УУХҮЯ-наас хийж байгаа ажлыг товчхон дурдвал, Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл хийгдэж байгаа, төслийн үзэл баримтлал үндсэндээ бэлэн болсон, саналууд аваад эцэслэсэн, хуулийн дагуу тандалт судалгаа, гарах үр дагавар мөн хууль хэрэгжсэнээр төрийн болон хувийн байгууллагуудаас гаарх зардлыг тооцож гаргах зэрэг ажлууд хийгдэж байгаа. Эдгээрийг хийсний дараа хуулийн үзэл баримтлалыг батлуулаад, цаашдаа хуулийн төсөл боловсруулах үндсэн ажилдаа орно. Өмнө нь хуулийн төсөл байгаа үүн дээр тулгуурлан ажиллана. Үүнээс гадна гэрээний ил тод байдлыг хангах ажил манай яамны хүрээнд эрчимтэй хийгдэж байна. 14 төрлийн 130 гаруй гэрээ, хэлцлийг ил тод болгоод байна. Ил тод гэрээний сайтад байршуулсан. Цаашдаа бичил уурхайн нөхөрлөлүүдтэй байгуулсан Засаг захиргааны гэрээг ил тод болгох болон газрын тосны бүтээгдхүүн хуваах гэрээг ил тод болгох талаар ажиллаж байна. Өнөөдрийн хуралдааны үйл ажиллагаанд амжилт хүсье, хуралдааны үйл ажиллагаа нээснийг мэдэгдэе.

Хуралдааны хэлэлцэх асуудал болон дэгийг уншиж танилцуулав.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлангийн төсөл

Г.Баянмөнх: БДО аудит компани ОУИТБС-ын 2018 оны 13 дахь удаагийн нэгтгэл тайланг бэлтгэхэд 10 сарын 3-ны өдрөөс хойш нилээд ачаалалтай ажилласан гэдгээ онцлон хэлье. Энэ төлөвлөсөн хугацаа маань төрийн байгууллагууд болон уул уурхайн салбарын байгууллагуудын нилээд их ачаалалтай үетэй давхцаж таарсантай холбоотой тайлангийн мэдээлэл цуглуулах ажилд нилээд олон бэрхшээлүүд гарсан. Тухайлбал, улсын төсөв батлуулах үе болон гуравдугаар улирлын аж ахуйн нэгжийн тайлангийн хугацаа давхацсаны улмаас мэдээлэл гаргаж өгөх явц удааширч, мэдээлэл цуглуулах процессыг сунжруулж үүний улмаас нэгтгэлийн тохируулга дээр ажиллахад хүндрэл гарсан гэдгийг хэлмээр байна. Бид гэрээний дагуу 11 сарын 29-нд нэгтгэл тайлангийн төслийг танилцуулах үүрэг хүлээсэн учраас өөрсдийн зүгээс хүний нөөцөө нэмэгдүүлж, уртасгасан цагаар ажилласнаар өнөө өглөө тайлангийн төслийг боловсруулж дууслаа. Энэ тайланд редактор хяналт хийж амжаагүй тул өгөгдсөн

мэдээлэлд үг үсэг, найруулга, тооны мянганы орон зэрэг дахин харах залруулах ажил байгаа гэдгийг хэлье. Ингээд манай нэгтгэлийн талбар дээр ахлаж ажилласан партнер Баярцогзол танилцуулгыг хийнэ. Уг тайлан өргөн их мэдээллийг хамарсан тул гол гол хэсгүүд дээр төвлөрөн аль болох товчхон цагтаа багтаан бид танилцуулгаа хийнэ. Баярлалаа

Л.Баярцогзол: ОУИТБС-ын 2018 оны 13 дахь удаагийн нэгтгэл тайланг БДО Тунисын хамтарсан концерциум хийж гүйцэтгэлээ. Тайлангийн зорилго нь тайлагнагч аж ахуйн нэгжүүдээс танилцуулагдах шаардлагатай мэдээллийг багтаасан 2018 оны ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлийн үр дүнг тайлагнах явдал юм. Бид тайланд уул уурхайн салбар, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалыг хамруулан авч үзлээ. Энэхүү тайланг ОУИТБС-ын 2016 оны стандартын дагуу хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Багийн бүрэлдхүүнд төслийг удирдаж байгаа Радхуан /гадаад зөвлөх/ хуралд ирсэн байгаа өөр хоёр гадаад зөвлөхүүд тухайн орон нутгаас ажилласан, Монгол талаас удирдах менежер Баянмөнх, чанарын хяналтын менежер Алтансүх болон бусад дотоод зөвлөхүүд нийтдээ 16 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

ОУИТБС-ын Цахим тайлангийн системээс авсан мэдээллээр Засгийн газрын тайлангаар 1986 байгууллага, компанийн тайлангаар 1490 байгууллага тайлан гаргасан байна. Засгийн газарт тайлангаа ирүүлээгүй компани 68, компанийн тайланд тайлангаа ирүүлээгүй 564 аж ахуйн нэгж байгааг тогтоосон. Томоохон 240 аж ахуйн нэгжийг шалгаад олборлох салбарт холбоогүй 39 компани байгааг тодорхойлсон. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 2018 оны 12 сарын байдлаар 3447 байсан энэ нь 2140 аж ахуйн нэгжид харъяалагдаж байна. 2018 оны нэгтгэл тайланд 202 компани хамрагдсан. Үүнд ашигт малтмалын олборлолт эрхэлдэг 22, хайгуул эрхэлдэг 120, хайгуул болон олборлолт эрхэлдэг 51, байгалийн хий газрын тосны олборлолт эрхэлдэг 8, ашигт малтмал байгалийн хий, газрын тосны хайгуул эрхэлдэг 1 компани сонгосон. Бид нэгтгэл тайланг ажлын даалгаврын дагуу таван үе шатаар гүйцэтгэхээр төлөвлөсөн. 2018 оны тайланд 2019 оны шинэчилсэн стандартаас шаардлага 2.4.с; 2.6.а.1; 6.3; 6.1; 6.4; 3.2; 3.3 болон 4.8 заалтуудад хамрагдах мэдээллийг тайлангийн төсөлд тусгасан байгаа.

Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын анхны зөрүү 110,8 тэрбум төгрөг байсан энэ нь нийт орлогын 4%-тай тэнцэж байна. Тохируулгын дараах зөрүү өнөөдрийн байдлаар 4,1 тэрбум төгрөг, энэ нь нийт орлогынхоо 0,15%-ийг эзэлж байгаа. Үүнд, компанийн төлсөн 98,3 тэрбум төгрөгийн орлого, Засгийн газрын байгууллагын хүлээн авсан 8,4 тэрбум төгрөг нийт 106,7 тэрбум төгрөгийн залруулгыг хийсэн байна. Нийт тохируулагдаагүй 4,1 тэрбум төгрөг нь дараах шалтгаантай байна гэдгийг олж тогтоосон. Үүнд, Засгийн газрын дэлгэрэнгүй төлбөрт байхгүй 5,1 тэрбум төгрөг, Засгийн газрын тайлагнаагүй татвар 1,3 тэрбум төгрөг, компани тайлангаа илгээгүй 76,7 сая төгрөг, Засгийн газрын дэмжих баримттай таараагүй болон компанийн дэмжих баримттай таараагүй зэрэг гол гол шалтгаанууд байна.

Бид стандартын шаардлагын дагуу холбогдох мэдээллийг нэгтгэл тайлангийн төсөлд оруулсан. Мөн эрхзүйн хүрээ ба төрөөс баримтлах бодлогууд хүрээнд олборлох салбартай холбоотой хууль тогтоомж, бодлого журамуудыг дурдаж оруулсан байна. Мөн уул уурхайн кадастрын мэдээлэлтэй холбоотой мэдээлэл, цахим хуудсанд ил тод байгаа мэдээллийг кадастрын албаны мэдээлэлтэй тулгаж оруулсан. Усны мэдээлэл, ажилтны талаарх мэдээлэл, стратегийн шинжтэй орд газруудын талаарх мэдээлэл болон бусад холбогдолтой мэдээллийг тайлангийн төсөлд оруулсан. ОУИТБС-ын өмнөх онуудын нэгтгэл

тайлангийн зөвлөмжийн биелэлт болон 2018 оны нэгтгэл тайланд өгөх зөвлөмжийг мөн бэлтгэн оруулсан байна. Энэ удаагийн тайлангаар Жендерийн тэгш байдлыг хэрхэн хангах, дэд зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, бенефициар эздийн мэдээллийг сайжруулах, Засгийн газрын байгууллагуудын хоорондын мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах, Засгийн газрын байгууллагууд болон компаниудын мэдээллийн иж бүрэн, гүйцэд тайлагналыг хангуулах, тайлангийн маягт болон цахим тайлангийн системийг хэрхэн сайжруулах зэрэг асуудлуудаар зөвлөмж бэлтгэн хүргүүлж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. /Тайлангийн төсөл, танилцуулгыг хавсаргав/

Ч.Цогтбаатар: Танилцуулга нийсэн БДО компанийн хамт олонд баярлалаа, асуудалтай холбоотой санал хэлэх гишүүд байна уу?

Н.Баярсайхан: Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн талаарх мэдээллийг оруулсан байна үүнийг зарлага буюу буцаан олголтоор гаргах боломж байна уу, БОАЖЯ тийм мэдээлэл өгсөн үү? Хог хаягдлын талаарх мэдээллийг компани тус бүрээр нь хэрвээ экспортолсон гэвэл аль хилийн боомтоор гарсан гэдгээр илүү задаргаатай харуулах боломжтой юу? Зөвхөн орлого харагдаад байгаа болохоор дутуу санагдаад байна. Мөн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөн гэдэгт газрын тос, уран түгээмэл тархацтай ашигт малтмал орсон байх баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн мэдээлэл хэр хамрагдаж чадсан бэ?

н.Буяннэмэх: Нөхөн сэргээлт байгаль орчны барьцаа хөрөнгийн талаарх мэдээг БОАЖЯ-наас хүлээн авсан. 2018 онд 1,2 тэрбум орчим төгрөгийн барьцаа хүлээн авсан буцаан олголт байхгүй гэж мэдээлсэн. Бид нэмэлт мэдээллийн маягтаар хог хаягдлын мэдээллийг компаниудаас хүлээн авч ирүүлсэн мэдээлэлд үндэслэн нэгтгэл тайланд оруулсан. Гаалийн ерөнхий газраас хог хаягдлын экспортын талаар ямар нэгэн мэдээ ирээгүй, баяжуулах үйлдвэрлэлийн талаар мэдээлэл хомс байгаа. Баяжуулах үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл авахаар хүргүүлсэн боловч мэдээлэл ирээгүй. Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг АМГТГ-аас авсан таны хэлээд байгаа мэдээлэл задраад орсон байгаа.

Н.Энхжаргал: Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын тоо 194, 202 болон 179 гэсэн өөр тоо гараад байна, үүнийг тайлбарлаж өгнө үү. Тайлангийн зөвлөмж дээр хугацаанд дууссан тусгай зөвшөөрөл хүчинтэй байна гэж дурдсан байна. АМГТГ-ын цахим систем дээр хугацаа нь дууссан зөвшөөрөл хүчинтэй байгаагаар харагдмааргүй юм энэ талаар тодруулж өгнө үү.

Буяннэмэх: Бид эхлэлтийн тайланд 196 компанид нэгтгэл хийнэ гэж тохирсон ч Ажлын хэсгээс нэмэлт шаардлага тавьж 8 компани нэмж оруулахыг хүссэн. Ингээд орлогын урсгалын нэгтгэл 202 компаниар байгаа. Дотор нь мэдээллээ задлаж харуулсан байгаа. Бид ОУИТБС-ын цахим тайлангаас тусгай зөвшөөрлийн мэдээллийг авсан АМГТГ-аас мэдээлэл аваагүй байсан. Энэ хүрээнд ОУИТБС-ын цахим системд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг тухай бүр шинэчлэх тухай зөвлөмжийг өгсөн.

Д.Цэрэнжав: Манай ОУИТБС-ын тайлан жил бүр сайжирч одоо харахад Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн талаарх тойм болж байгаа. Нэг том дутагдал бол жилийн өмнөх мэдээлэл байдаг. Үүнтэй холбоотойгоор тайланг дагаж ордог хавсралт буюу түүхий мэдээлэл чухал ач холбогдолтой. Үүнийг дахин боловсруулж, шинэчлээд судлаачид болон бусад хүмүүс хэрэглэх боломжтой чухал мэдээлэл байдаг. Өнөөдрийн тайлангийн төсөлд танилцуулсан тоонуудыг ил

тод болгон тараахад хязгаарлах зүйл байна уу? багтахгүй гэх асуудал байна уу? энэ талаар тодруулж өгөхийг хүсье. БОАЖЯ-наас мэдээллийг хэр хангалттай өгсөн бэ? жишээлбэл, Нөхөн сэргээлтийн эрхтэй компаниудын талаар мэдээллийг өмнө жил зөвхөн нэрсийг жагсаасан байсан. Бид нэр, харъяалал, орон нутгийн талаар мэдээлэл оруулах хүсэлт тавьж байсан, энэ хэр ахицтай өөрчлөлтэй байна вэ? Мөн жил бүр ГЕГ-ийн талаар яриа гарч байдаг, үүний учир шалтгаан нь ямар юм бол та нарт ямар тайлбар өгч байсан бэ? энэ талаар хариулж өгнө үү.

Буяаннэмэх: Тайлангийн нэгтгэл тайланд 2018 оны тоон мэдээлэлд тулгуурлан хийж байгаа, нэмэлт мэдээлэлд хууль тогтоомж болон бусад мэдээллүүдийг үгэн хэлбэрээр оруулсан байгаа.

Баянмөнх: Бид цуглуулсан мэдээллийг боломжит түвшинд хавсралтад оруулах боломжтой гэж бодож байна, хуулиар заагдсан нууцлалын зэрэгт орсон мэдээлэл биш л бол оруулах боломжтой. Харин мэдээллийн багтаамжаас хамаараад ямар хэлбэрээр хавсаргах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй байх. БОАЖЯ-наас тодорхой хэмжээний мэдээллийг авч ашиглаж чадсан үүний тулд нилээд хэмжээний хүчин чармайлт, уулзалт хийж байж мэдээллийг авсан нь ахиц болсон байхаа.

Буяаннэмэх: Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тухай мэдээллийг 2018 оны байдлаар өгсөн одоогийн байдлаар 14 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа гэсэн. 2019 оны 10 сард барьцаа хөрөнгийг компани бүрээр задлаад тодорхой болгосон гэсэн ч бидэнд өгөөгүй. Удахгүй бүх мэдээлэл өөрийн сайтад тавигдаж нээлттэй болно гэсэн мэдээллийг БОАЖЯ-наас ирүүлсэн. Гаалийн ерөнхий газарт гурван удаа бичиг явуулж байж мэдээлэл авсан боловч зөрүүтэй мэдээлэл ирсэн. Тохируулагдаагүй 4,1 тэрбум төгрөгийн зөрүүгийн ихэнх нь ГЕГ-т байгаа, зөрүүг компани бүрээр гарган дахин мэдээлэл, тодруулга авахыг хүссэн. Өнгөрсөн 5 дахь өдөр хариу нь ирсэн байгаа, бид эцсийн тайлан танилцуулах хугацаа хүртэл ирсэн мэдээлэлд үндэслэн зөрүүг буулгах боломжтой. Харин бусад ерөнхий мэдээллийг хүссэн боловч ирүүлээгүй байгаа.

Л.Баярцогзол: ОУИТБС-ын цахим тайланд өгсөн тайлангийн дүнгүүд буруу дүнгүүд, бидний явуулсан албан бичгийн хариуд засчихлаа гээд өөр дүнгүүд өгч байгаа. Бид нар шууд энэ мэдээлэл итгэх боломжгүй тул дахин дэлгэрэнгүй нотолгоо шаарддаг. Компанийн мэдээлэлтэй тулгахад дахин зөрүү гараад бид дахин хүсэлт тодруулга авахыг хүссэн. Мэдээлэл зөрүүтэй байгаа нь зарим нэг боомт орхиод мэдээгээ татсан байх зэрэг алдаанууд ажиглагдаад байгаа.

Г.Баянмөнх: Өмнөх тайлагналын хувьд ямар байсныг бид мэдэхгүй. Бидний хувьд 2020 оны төсөв батлахад гол хүмүүс нь төвлөрөөд бидэнд мэдээлэл гаргаж өгөх хугацаа хойшлох, улмаар тайлан боловсруулахад цаг хугацааны хувьд шахагдах зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн. Цаашид энэ тайланг оны эхний хагас жилдээ багтаагаад, тайлагналын хувьд улирлын тайлагналын үетэй давхцуулахгүй зохион байгуулвал бусад байгууллагуудтай хамтарч ажиллахад илүү бололцоотой санагдсан. Иймд цаашдаа гэрээ хийх процесс, тайлан бэлтгэх цаг хугацааг анхааралдаа авахыг хүсэж байна.

Ш:Цолмон:Тайланд ашиг хүртэгч эздийн талаарх мэдээлэл ороогүй байна юм шиг харагдаж байна. Энэ талаарх нэмэлт мэдээллийн маягтаа компаниудаас ирүүлээгүй гэж ойлгох уу?

Буяннэмэх: Ашиг хүртэгч эздийн талаарх мэдээллийн маягтыг бүх компанид явуулсан үүнээс 60 компани мэдээллээ ирүүлсэн. Бид өнгөрсөн оны мэдээллийг хэвээр оруулаад, ирүүлсэн 60 компанийн мэдээллийг шинэчлээд хавсралтаа бэлдсэн байгаа.

Ч.Цогтбаатар: Ажиллагчдын тоо 32211 гэсэн мэдээлэл оруулсан байна. Миний санахад 2017 онд олборлох салбарт ажиллаж байгаа хүний тоо 52 мянга байна гэсэн тоо гарсан байсан. Зөвхөн Оюутолгой компанид гэхэд 16 мянган хүн ажилладаг гэсэн тооцоо байдаг үлдсэн тал хувь нь бусад олборлох салбарын компаниудад ажиллаж байна гэсэн өрөөсгөл ойлголт гарах гээд байна, үүнийг тодруулах. Уул уурхайн салбарын улсын төсөв оруулсан орлогыг харуулсан байна. Энэ нь зөвхөн үндсэн компани байгаа байх. Үүнээс гадна туслан гүйцэтгэх компаниудын мэдээлэл маш том тоо гарна, үүнийг оруулах боломжтой юу? Мөн төмөр замаар орж ирж байгаа ачаа тээврийн ихэнх нь нефть, шатахуун байдаг үүнийг олборлох салбар хэрэглэж байна, цахилгаан эрчим хүчний ихэнхийг энэ олборлох салбар хэрэглэж байна. Тэгэхээр эдгээр мэдээллүүдийг ОУИТБС-ын тайланд оруулвал маш том эдийн засагт үзүүлэх нөлөөлөл гарч ирнэ. Иймд туслан гүйцэтгэх компаниудын талаарх мэдээллийг оруулах боломж байхгүй байсан уу?

Буяннэмэх: Ажилчдын мэдээллийн хувьд маягтын дагуу мэдээллээ ирүүлсэн компанийн мэдээлэлд үндэслэн гаргасан зарим компаниуд ерөнхий мэдээллийг ирүүлээд нэмэлт мэдээллийг маягтыг бөглөж ирүүлээгүй байгаа. Бид үүнийг дахин тодруулж нягтлах цаг хугацаа байгаагүй учраас зөвхөн ирүүлсэн мэдээллийг дагуу тайланд оруулсан. Бид статистикийн мэдээлэлтэй тулгаж дахин нягтлан харъя.

Тайлангийн маягтад туслан гүйцэтгэх компанийн талаарх бөглөх дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй учраас зөвхөн үндсэн компанийн мэдээллийг нэгтгэсэн байгаа. Хэрвээ тийм мэдээлэл гардаг бол компанийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцоход чухал үр нөлөөтэй байх.

Г.Баянмөнх: Бид эцсийн тайлан хийхийн өмнө ажилчдын тооны талаар дахин нягталж үзээд, оруулсан мэдээллээ илүү тодотгож, ямар хүрээнд авч үзэхэд ийм байгаа талаар тайлбар, эх сурвалжийг оруулъя. Олборлох салбарын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн хувьд бид нэгтгэлд хамрагдсан компанийн тоон мэдээлэлд үндэслэн бэлтгэгдэж байгаа гэдгээ онцгой анхаарах ёстой. Эдийн засгийн мэдээллийн хувьд Засгийн газрын байгууллагуудаас гарч байгаа мэдээлэл илүү эх сурвалжтай гэж үзэж шинэчилж байгаа. Бидний хийх ажлын хүрээнд багтаагүй мэдээллийг бид оруулж хийхэд хүндрэлтэй гэдгийг онцлон хэлье.

Н.Баярсайхан: Тэгэхээр ОУИТБС-ын цахим тайланд компаниудын өгч байгаа мэдээлэл, тодруулга авахаар засаад өөр тайлан өгч байна гэлээ. Цахим тайлан маань удирдлагын хариуцлагын гарын үсэгтэй ирж байгаа, энэ нь сул байна уу? хэрвээ тийм бол үүнийг яаж сайжруулах талаар санал дүгнэлт гаргах хэрэгтэй байх.

Жилээс жилд бичил уурхайд өгч байгаа зөвшөөрөл, газрын хэмжээ нэмэгдээд байгаа юм байна. Үүнээс харахад албан ёсны зөвшөөрөлтэй газар нь хариуцлагагүй ажиллаад, албан бус байгууллага нь илүү хариуцлагатай ажиллаад байгаа дүр зураг харагдаад байна. Энэ асуудал дээр та нар ямар дүгнэлт хийж байна вэ? дүгнэлтэндээ оруулж өгөхийг хүсье. Усны ашиглалтын мэдээлэл оруулсан байна харин нэмээд хэдий хэмжээний төлбөр орлого орсон байна гэдгийг харуулвал ач холбогдолтой болохоор байна. Хандив дэмжлэгийг дөрөв ангилсан

байна, дөрөв дэх нь юу вэ? Мөн хамгийн их хандив дэмжлэг өгсөн мэдээлэл байна, үүнд Дорноговийн хөгжил сан мэдээгээ тайлагнасан уу? Энэ сан 2017 онд 2,2 тэрбум төгрөгийг хуримтлуулсан гэсэн мэдээ байсан ч жил бүрийн тайланд орохгүй байна, үүнийг ил тод нээлтэй болгох боломж байна уу?

Нөхөн сэргээлтийн буцаан олголт 2017 онд байхгүй гэж байсан 2018 онд бас байхгүй гэсэн байна. Энэ мөнгө нь авах гэхээр байхгүй байдаг юм уу, компаниуд авах хүсэлтээ гаргахгүй байна уу? эсвэл өгөхгүй байх талаар нууц шийдвэр байна уу? гэдгийг тодруулаад яагаад буцаан олголт хийгдэхгүй байгаа талаарх шалтгааныг тогтоон дүгнэлт зөвлөмж гаргавал илүү их ач холбогдолтой болохоор байна гэсэн санал байна. Мөн баяжуулах боловсруулах үйлдвэрүүд туслан гүйцэтгэх компаниудтай адил үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр энэ үйлдвэрүүд энэ жилдээ өөрөө баяжуулах үйлдвэртэй, бусдаар баяжмал аваад баяжуулж байгаа гэсэн хоёр ангилалаар гаргаад тус бүрийн төрөл, хүчин чадал, бүтээгдхүүн экспортолсон мэдээлэлтэй нь гаргаад ерөнхий дүр зурагтай болгох зайлшгүй шаардлага байна. Яагаад гэвэл энэ нь АМНАТ-аас чөлөөлөгдөх тухай асуудал яригдаад нилээдгүй хэл ам дагуулж байгаа. Иймээс 2020 онд Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль болон татвар дээр яригдана. Үүнд 2018 оны тайлан гол эх суурь болох учраас дээрх мэдээллийг оруулахыг хүсэж байна, энэ их чухал юм. Хог хаягдлын мэдээллийг компани бүрээр нь дата мэдээлэлд оруулж өгвөл зүгээр байна, энд нууцын зэрэглэл байхгүй. БОАЖЯ болон ГЕГ нь ОУИТБС-ын тайлагналд оролцох статустай байгууллага байдаг гэвч жил бүрийн тайлан мэдээлэлд хойрго ханддаг, хуралд оролцдоггүй гэдэг талаар жил бүр ярьсаар байдаг. Иймд энэ хоёр байгууллагыг яаж идэвжүүлж ажиллах талаар анхаармаар байна. За баярлалаа.

Баяраа: Компанийн ажилчдын талаарх мэдээллийг та бүхэн компаниас авсан ч гэсэн харьцуулаад хийх статистик мэдээлэл ер нь олддог. Харьцуулж хийхгүй болохоор хэтэрхий хараат ерөөсгөл мэдээлэл болж байна, татвар болон нийгмийн даатгалд өгч байгаа мэдээлэлтэй харьцуулж оруулмаар байна. Бичил уурхайн мэдээллийг харахад төлсөн татварийн дүн нь өндөр байгаад байна. Энэ нь үнэхээр бичил уурхайчид тушаагаад байна уу эсвэл аж ахуйн нэгжүүд өөрсдийн олборлосныг бичил уурхайн мэдээлэлд оруулаад өгөөд байна уу гэдгийг салгаж мэдээллээ цуглуулмаар байна. Мөн нөхөн сэргээлтийг бичил уурхай хийсэн гэж харагдаж байна үнэхээр өөрсдөө хийж үү, татвар төлж байна уу гэдгийг тодруулах санал байна.

Л.Бор: Жилээс жилд ОУИТБС-ын тайлан сайжирч байгаа, харин энэ тайлангаа олон нийтэд хүргэх ажил хаягдсан байгаа. Үүнийг цаашид хөдөө орон нутгаас ирж байгаа төрийн байгууллагын хүмүүст тараах, түүнийг дагаад уул уурхайг хариуцлагажуулах тухай тогтоол шийдвэр гаргавал сайн байх. ОУИТБС-ын тайлангаас олон мэдээллүүдийг авах боломжтой байдаг иймээс тайланг хурдлаа гэж үзэж болохгүй байх гэж бодож байна. Өмнө Засгийн газрын хоёр тогтоол гарсан, түүнийг орон нутагт хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тусгахыг хүсэж байна.

Ж.Батцэнгэл: Юуны өмнө тохируулгын өмнөх зөрүүг тулган баталгаажуулж 0,15%-д хүртэл бууруулсан БДО аудитынхандаа баяр хүргэе. Тайлангийн мэдээлэлд хүлээн авсан орлогоо тайлагнаагүй 109 тэрбум төгрөг гэсэн тоо байна. Үүнийг тодруулмаар байна, Засгийн газрын дүнд ийм том дүн баймааргүй юм. Манай байгууллага тайлангаа явуулахын өмнө Эрдэнэтийн талаар ажиллаад

тааруулаад явуулж байсан чинь энэ тайланд зөрүү байна гэж яригдаад байна, энэ ямар учиртай юм бол гэдгийг тодруулга авмаар байна.

Буяннэмэх: Эрдэнэт үйлдвэрт хүлээн авсан татвар болон ногдол ашиг гэсэн том дүн байгаа. Дээр нь компаниудаас хүлээж авсан хандивын мэдээллийг тайлагнаагүй байгаа. Бид холбогдох байгууллагуудаас тодруулга авахад орон нутаг дээр хандив, улсын төсөвт ногдол ашгийн талаар тайлагнаагүй учраас томоохон зөрүү харагдаж байгаа.

Ч.Цогтбаатар: Бичил уурхайчдын мэдээллийг ийм байдлаар харуулж болохгүй. Хуулиараа иргэд алт тушааж болдог, компанийн хүмүүс гэр бүлийн хүний нэр дээр алтаа тушаасныг нь бичил уурхай тушаасан гээд бүртгэдэг. Хамгийн их үйл ажиллагаа явуулж алт олборлож байгаа компаниуд байхад бичил уурхай илүү давуу мэтээр харагдуулж, төөрөгдүүлж болохгүй гэдгийг хэлмээр байна. Орон нутгийн хандив тусламжийн асуудал хөндөгдөж байна. Дорнод аймагт компаниудтай гэрээ хийгээд борлуулалтын орлогын 3 хувийг авдаг энэ нь бараг АМНАТ-ын татвартай иж хувьтай байдаг. Ийм тохиолдол, гэрээнүүд зөндөө байгаа. Иймээс орон нутаг түүнийгээ ил болгох хэрэгтэй. Ялангуяа Дорнод аймгаас авах хэрэгтэй гэж бодож байна. Мэдээж хэрэг хувьдаа ашиглаагүй ч орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хэрхэн зарцуулж байгааг тодорхой хэмжээнд ил тод болгох хэрэгтэй. Компаниудаас маш их хандив, тусламж авдаг тохиолдол орон нутагт зөндөө байгаа.

Баяраа: Лиценз шилжүүлэхэд 30 хувийн татвар төлдөг болсон, орд шилжүүлэхэд бас тийм болгомоор харагдаад байна.

Буяннэмэх: Энэ талаар тайлангийн маягыг сайжруулах тухай ажлын хэсэгт өгөх зөвлөмжид оруулах боломжтой.

Баяраа: Гишүүдээс гаргасан санал тайланд тусгагдсан эсэхийг дараа нь шалгаж, тулгаж үзмээр байна, тэгэхгүй бол аль орсон ороогүйг мэдэхгүй болно.

Ч.Цогтбаатар: Ажлын алба гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн хэнээс ямар санал гарсан, тайланд туссан талаарх мэдээллийг нэгтгэн нягтлаад тайланг цааш нь явуулах санал гаргаж байна, боломжтой юу?

Н.Баярсайхан: Одоо энэ тайланг харахад учир дутагдалтай юм их байна. Энэ нь биднээс шалтгаалж байгаа юм ч байгаа, та нараас шалтгаалж байгаа юм ч байгаа байх. Үндэсний зөвлөлийн хуралдаанд 12 сарын 19-нд оруулах юм байна. Үүнээс наана гишүүдийн гаргасан саналыг тусган сайжруулах байх. Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулаад шийдвэр гараад мөнгөө авчихлаа гээд цаашаа харах биш, хэвлэлтэнд орохоосоо өмнө сайн хянаж нягтлаж ажиллах хэрэгтэй байна, тэгэхгүй болд бид нилээн эргэлзээтэй мэдээлэлтэй үлдэх гээд байна. Мөн найруулга, үг үсгийн алдаа цаашлаад орчуулга гэх мэт анхаар нарийн юмнууд байна, үүнийг тусгаж шийдвэрийн төсөлдөө оруулах саналтай байна.

Л.Бор: Өмнөх хурал дээр эрдэс баялагийн салбарын ангилал дээр ураныг тусад нь оруулъя гэж ярьсан. Энэ талаарх мэдээлэл орсон уу?

Л.Баярцогзол: ураны компаниудын талаарх мэдээлэл тайланд орсон байгаа хаана орсныг бид дараа нь тантай холбогдоод хэлж өгье.

Ч.Цогтбаатар: Тайлангаа сайжруулах тал дээр сайн ажиллах хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: БОАЖЯ болон Гаалийн ерөнхий газар мэдээллээ гаргаж өгөхгүй зэрэг бэрхшээлүүд байгаа юм байна иймд төрийн байгууллагууд мэдээллээ өгч дэмжиж ажиллах талаар шийдвэрийн төсөлдөө тусгахыг санал болгож байна.

М.Энхжаргал: Нөлөөллийн үнэлгээг хийхдээ хэдэн компанийг хамруулан хийсэн талаарх тайлбарыг хүснэгтийн доор оруулахыг хүсье Тэгэхгүй бол үнэлгээ нь нийт уул уурхайн салбарын хэмжээнд юмуу, тайланд хамрагдсан компаниудын хувьд юм уу гэдэг нь ойлгомжгүй, үнэлгээ нь учир дутагдалтай гарах гээд байгаа учраас тайлбар хийх нь зүйтэй гэсэн санал гаргаж байна.

Ч.Цогтбаатар: Саяхан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Баяжуулах үйлдвэрүүдэд тавигдах шаардлага гэдэг шинэ журам батлагдсан байгаа. Үүний дагуу Баяжуулах үйлдвэрүүд тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж эхлээд байгаа, мэдээлэл нь байгаа тохиолдолд манай уул уурхай мэдээлэл технологийн хэлтсээ мэдээллийг авах боломжтой. Мэдээлэл нь байхгүй юмыг байхыг үгүйсгэхгүй, ирэх оноос цэгцлээд явна гэж ойлгож болно.

Н.Баярсайхан: Хуралдааны шийдвэртээ БОАЖЯ, ГЕГ-т үүрэг болгож оруулмаар байна.

Ч.Цогтбаатар: БОАЖЯ-наас ажлын хэсэгт байдаг болохоор холбогдох хүнд нь мэдээлэл хүргүүлж, анхаарч ажиллахыг ажлын албанаас дамжуулсан нь зөв байна. За эхний асуудлыг үүгээр дуусгая, шийдвэрийн төслийг баталлаа. БДО аудитынханд баярлалаа.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: 2019 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц, 2020 оны ажлын төлөвлөгөөний төслийн танилцуулга

Ш.Цолмон: 2018 оны нэгтгэл тайлангийн талаар чухал шийдвэр гаргаж байгаадаа баяртай байна. 2019 онд нийт 40 ажил төлөвлөсөнөөс 11 ажил хийгдсэн. Санхүүжилт гацсан, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас яаралтай арга хэмжээ авч, Сангийн яамтай хамтран ажилласнаар Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк (ЕСБХБ) болон Азийн хөгжлийн банк (АХБ)-наас санхүүжилт авч эхэлсэн. ЕБСХБ-наас 49,000 еврогийн санхүүжилт авахаар тохирсон, АХБ 2021 оны 11 дүгээр сарыг дуустал санхүүжүүлэхээр 300 гаруй мянган долларын Техник туслалцааны төсөл хэрэргжихээр болсон. ЕСБХБ-ны санхүүжилтийн дараа АХБ-ны санхүүжилт орж ирэхээр төлөвлөсөн. ЕБСХБ-ны санхүүжилт удсаны улмаас ажил жаахан зогссон, зарим ажилтнууд өөр ажилд шилжсэн байна. Мэдээллийн технологийн ажилтнаар О.Мөнхбат гэж хүн орсон, харин харилцааны мэргэжилтэн одоог хүртэл байхгүй байгаа АХБ-наас сонгон шалгаруулалтыг хийж байгаа ч энэ чиглэлийн хүн олдохгүй байгаа учир хүлээгдэж байна.

2019 онд хийсэн гол ажил бол ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлангийн ажлыг эхлүүлэх суурь дэвсгэрийг тавьсан. Хамгийн гол нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ОУИТБС-ын тайлан гаргахад хамтарч ажилласан. Бидний тооцоогоор 2139 компани тайлан гаргахад 1490 компани тайлан гаргасан, 6 агентлаг, нийслэл 9 дүүрэг тайлан гаргаж 1986 компаниас орлого хүлээн авсан

байна. Яам агентлаг гэрээний ил тод байдлын портал гаргаж, гэрээний ил тод байдлаар хамтран ажилласан. ОУИТБС-ын тайлан гаргах үүрэг бүхий төрийн бүх шатны байгууллагуудтай холбогдож, мэдээлэл өгөх, аргазүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зохион байгуулсны үр дүнд 1986 компаниас орлого хүлээн авснаар 6 агентлаг, нийслэл, 8 дүүрэг, 13 аймаг тайлан гаргасан байна. УУХҮЯ, Нээлттэй нийгэм форумтай хамтран 4 дүгээр сард “Гэрээний ил тод байдлын” порталыг албан ёсоор нээх ажиллагааг зохион байгуулах ажлыг хийх хэсэгт орж ажиллан бэлтгэлийг хангуулахад оролцсон байна. 280 гэрээг ил тод болгож, нийтлүүлсэн байна. Мөн арга хэмжээний хүрээнд орон нутгийн гэрээний асуудлаар хийгдсэн олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг зохион байгуулан, илтгэл тавьж, хурал удирдсанаас гадна гэрээний ил тод байдлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийг урьж “Төслийн түвшиний тайлагнал”-ын асуудлын танилцуулсан байна. Мөн ОУИТБС-ын стандартын нэмэлт шинэ шаардлагын танилцуулга хийсэн. 5 дугаар сард ОУИТБС-ын олон улсын нарын бичгийн газрын гүйцэтгэх захирал Марк Робинсон, захирал Ольяна Валигура нарын айлчлалыг зохион байгуулсан бөгөөд уулзалтын хүсэлтийг УУХҮ-ийн сайд, ЗГХЭГ-ын дарга, УУХҮЯ, Татварын ерөнхий газар, Эрдэнэс Монгол ХХК, ОУИТБС-ын Компаний болон Иргэний нийгмийн төлөөлөл, Хандивлагч орнуудын төлөөлөгчдөд тавьсаны хэдий ч ЗГХЭГ-ын дарга, УУХҮ-ийн сайдаас бусадтай уулзалтуудыг зохион байгуулсан байна. Энэ айлчлалын үеэр Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүд болон төрийн захиргааны байгууллагуудын дугуй ширээг зохион байгуулж, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг уулзалтад УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн оролцож, үг хэлсэн байна. ББЗХ, Транспаренси интернейшнл ТББ-ын төлөөллийн хамт УИХ-ын гишүүн Ундраад бараалхаж, ОУИТБС-ын талаар танилцуулга хийж, цаашид ажиллах чиглэлээр санал солилцсон болно. 6-р сард Парис хотноо зохиогдсон ОУИТБС-ын олон улсын бага хуралд УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Оюу толгой ХХК-ийн менежер Т.Мөнхбат, ТАН эвслийн зохицуулагч Б.Баярмаа, Ажлын албаны МТ-ийн зөвлөх Г.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцов. Мөн Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа ОУСК-ийн зардлаар, Энержи ресурс ХХК-ийн захирал Г.Сугармаа компанийхаа зардлаар оролцсон. Транспереси Интернейшнл ТББ-ын Монгол дахь зохицуулагч Л.Төр-Од мөн оролцсон байна. 2018 оны нэгтгэл тайлан гаргах Хараат бус хянагч нэгтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо 5 хуралдаж, оролцогч нарын зүгээс гомдол гаргасан учир Сангийн яамнаас дахин зарлах шийдвэрийг гаргаснаар Үнэлгээний хороог дахин өөрчлөв. Тендерийг 7 дугаар сард дахин зарлаж, тендер 8 дугаар сарын 15-наар амжилттай дууссан байна. Үнэлгээгээр сонгогдсон БДО компанитай 8 дугаар сарын 30-нд гэрээгээ байгуулж 9 сарын 2-ноос ажлаа эхэлж байна. Үйл ажиллагааны тайланг гишүүдэд тараасан байгаа болохоор товчхон танилцуулж байна. /Танилцуулгыг хавсаргав/

2019 онд нийтдээ 40 ажил хийхээр төлөвлөснөөр 11 ажил нь хийгдсэн, хэрэгжилтийн байдалтай байгаа гэж дурдсан, хийгдээгүй ажлуудыг 2020 онд шилжүүлэхээр төлөвлөж, саналыг та бүхэнд тараасан байгаа. Ирэх онд 11 зорилтын хүрээнд 40 үйл ажиллагааг хийхээр төлөвлөж танилцуулсан. **Нэгдүгээрт** “ОУИТБС-ыг стандартын шинэ шаардлагуудыг нэвтрүүлэх, төрийн

байгууллага, компанийн олон нийтэд зориулсан сүлжээгээр ил тод болгох ажлыг хэвшүүлэх” зорилгын хүрээнд дөрвөн зорилт бүхий 16 үйл ажиллагаа, **Хоёрдугаарт** “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дахин боловсруулж, УИХ-аар батлуулах” зорилтын хүрээнд таван үйл ажиллагаа, **гурвдугаарт** “Ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог сайжруулах, туршилтаар мэдээлэл цуглуулах” зорилгын хүрээнд хоёр зорилт бүхий зургаан үйл ажиллагаа, **Дөрөвдүгээрт** “Монгол улсын ОУИТБС-ын 2018 оны тайлангийн явцыг сайжруулах, тайланг хэлэлцэн батлах” зорилгын хүрээнд таван үйл ажиллагаа, **Тавдугаарт** “Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөө, ач холбогдол мэдээлэл сургалт суртчилгааны ажлыг идэвхжүүлэх” зорилгын хүрээнд гурван зорилт бүхий 8 ажлыг хийхээр төлөвлөсөн байна. Ингээд оролцогч талуудаас ирэх оны ажлын төлөвлөгөөнд оруулах саналаа өгнө үү, эдгээрийг нэгтгээд Үндэсний зөвлөлийн хуралд оруулах саналтай байгаа. Та бүхнийг хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Ч.Цогтбаатар: 2019 оны төлөвлөгөөний биелэлт, 2020 оны төлөвлөгөөний төслийн талаар танилцуулга хийсэн Цолмон гуайд баярлалаа. Тайлан болон төлөвлөгөөний төслийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн байгаа. Төлөвлөгөөтэй холбогдуулаад санал байвал хэлэхийг ажлын хэсгийн гишүүдээс хүсье.

Ш.Цолмон: Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах хүртэл сар хүрэхгүй хугацаа байгаа, энэ хооронд мартагдсан нэмж оруулах санал байвал оруулж болно. Дараагийн танилцуулах хоёр асуудал дээр бид нилээд ажиллах хэрэгтэй юм шиг байна тэгж байж 2020 онд хийх ажил ойлгомжтой болох юм. Иймд дараах танилцуулгын дараа саналаа нэгтгээд хэлж болно. /Танилцуулгыг хавсаргав/

III. ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын стандартын дагуу тайлангийн маягтыг шинэчлэх тухай танилцуулга

Ш.Цолмон: Стандартын дагуу шинэчлэх тайлангийн маягтыг тараасан байгаа. Уг маягтуудыг та бүхэн мэдэж байгаа, эдгээр 14 маягтын дагуу нэгтгэл тайланд хамрагдаж байгаа компаниудаас мэдээллээ авдаг үүний дагуу аудиторуд маань нэгтгээд манай ерөнхий мэдээлэл дээр нэмээд баталгаажуулалтандаа оруулдаг. Үүнийг 2019 оны шинэ стандартын дагуу жаахан өөрчилж баяжуулсан, цоо шинээр хийсэн юм байхгүй. Эдгээр тайлангийн маягтууд манай систем дээр байгаа үүнийг нэгтгэл тайланд хамрагдсан компаниуд бөглөдөг, 2017 оны нэгтгэл тайланд хамрагдсан компаниудаас бараг 70,80 нь уг маягтыг бөглөж ирүүлээгүй байсан. Маягтын Ерөнхий мэдээллийн хүснэгтэд компанитай холбоотой мэдээллүүдийг нэгтгэн харуулснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг илүү хялбар, эмх цэгцтэй болгож, ашиглахад хялбар болох бололцоотой. Мөн төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэлд сүүлийн гурван баганын мэдээлэл буюу томилогдсон шийдвэрийн дугаар, огноо, Хэдэн жил ТУЗ-д байгаа, Улс төрийн нам, эвслийн гишүүн эсэх, хэвээр эсэх гэсэн мэдээллийг нэмж оруулсан.

Цаашилбал Ажилтнуудын талаарх мэдээлэлд стандартын дагуу жендерийн талаарх мэдээллийг оруулсан, ашиг хүртэгч жинхэнэ эздийн талаарх мэдээлэл өөрчлөлт оруулсан байгаа, бусад мэдээллүүдэд ажлын албаны зүгээс өөрчлөлт оруулаагүй байна. Үүнийг бид ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөр баталчихвал дараа нь Үндэсний статистикийн хороогоор батлуулах юм. Мэдээллээс хувийн

нууцын чанартай асуудлуудыг хувийн нууцын хуультай холбоотой мэдээллийг хассан. Бусад хог хаягдал, зээл зээлийн баталгаа, ногдол ашгийн талаарх мэдээлэл хэвээр байгаа. Хэрвээ эдгээр маягтыг Статистикийн хороогоор батлуулчихвал заавал тайлагнах маягт болох юм, энэ нь компаниудад их ачаалал болохгүй байх. Нэгтгэл тайланд хамрагдаж байгаа компаниудын ихэнх нь эдгээр маягтуудыг бөглөж сурсан байгаа иймд компаниуд маань дэмжих болов уу гэж найдаж байна. /Танилцуулгыг хавсаргав/

IV. ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн байгууллага, төрийн өмчийн компанийн олон нийтэд зориулсан мэдээллийн сүлжээнд ОУИТБС-ын стандартын дагуу мэдээллийг байршуулах тухай Засгийн газраас гаргах тогтоолын хавсралтын төслийн тухай танилцуулга

Ш:Цолмон: 2017 оны ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар төрийн байгууллага, төрийн өмчийн компанийн олон нийтэд зориулсан мэдээллийн сүлжээнд ОУИТБС-ын стандартын дагуу мэдээллийг байршуулах тухай Засгийн газрын тогтоолын хавсралтын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулахаар ярилцсан. Гэвч 2018 онд Уул уурхайн яаманд бүтцийн өөрчлөлт хийгдэж, энэ талаар ямар нэгэн ажил хийгдээгүй мөн дараа нь ажлын алба санхүүжилтгүй болсон. Одоо нөхцөл байдал гайгүй болж байгаа болохоор энэ ажлаа хийж, Засгийн газрын тогтоол гаргуулахгүй бол үүнд Сангийн яам, БОАЖЯ болон бусад агентлаг, аймгууд хамрагдаж байгаа бөгөөд сайдын тушаалыг хүлээн зөвшөөрөхгүй. Иймд Засгийн газрын тогтоол гаргуулах шаардлагатай байна.

Үүнд холбогдох төрийн захиргааны бүх шатны байгууллагуудаас гаргах, ОУИТБС-ын тайланд тусгах болон цахим хуудас дээрээ байршуулах мэдээллийн жагсаалт гээд яам тус бүрээр ямар ямар мэдээллийг ил тод байршуулах судалгааны дагуу оруулахаар бэлтгэсэн байна. Тухайлбал, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам нийтдээ таван төрлийн мэдээллийг ил болгож мэдээлэхээр оруулсан. Үүнд, эрдэс баялагийн мөрдөж буй бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам болон холбогдох төрийн байгууллагуудын чиг үүргийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, Эрдэс баялагийн салбарт хийж буй бодлогын шинэчлэлийн мэдээлэл, гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагааны мэдээлэл, www.iltodgereee.mn мэдээллийн санд бүх гэрээний мэдээлэл оруулах, ОУИТБС-ын цахим порталын холбоосыг байршуулахаар тусгасан бөгөөд эдгээрээс шинээр оруулах хоёр мэдээлэл бусад нь одоо байгаа. Түүнчлэн Сангийн яам төсвийн бодлого, төсвийн хуваарилалтын мэдээлэл, орон нутгийн шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон шууд шилжүүлгийн мэдээлэл зэрэг 10 төрлийн мэдээллийг оруулахаас шинээр оруулах нь таван мэдээлэл байна гэх мэтчилэн бусад яам агентлаг тус бүрээр жагсаалтыг бэлтгэсэн байгаа. Эдгээр асуудлыг баталснаар Үндэсний зөвлөлд оруулах бололцоотой болно гэдэг үүднээс та бүхэнд танилцуулж байна. Та бүхэнд баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Пүрэв: Маягтын 4-ын 1.3-т олборлолт, борлуулалтын мэдээ гэсэн байна энэ нь зөвхөн газрын тосны олборлолт борлуулалт юм уу эсвэл зөвхөн бүтээгдхүүний олборлолт борлуулалтын бичих гээд байна уу?

Ш.Цолмон: Бүтээгдэхүүн бишээ, олборлолт борлуулалтын мэдээлэл юм.

Пүрэв: Тэгвэл бүтээгдэхүүн гэдэг үгээ авах юм байна, 4.1.3 болон 4.1.3а маягтуудад орсон давхацсан юмнуудыг хасчихмаар байна.

Ш.Цолмон: Болно оо

Пүрэв: Манай яам газрын тосны эрлийн гэрээ байгуулаад ажиллаж байгаа, газрын тосны гэрээн дээр эрлийн гэрээг ил тод болгохоор ажиллаж байна. Энэ маягтад тусад нь олборлолт борлуулалтаас гадна эрэлийн талаарх мэдээлэл оруулахаар болгочихвол зүгээр байна, нийтдээ 10 гаруй компани байдаг үүнийг энд оруулах боломжтой юу тусад нь байх уу?

Ш.Цолмон: Мэдээллийг нэмж оруулж болно, маягтыг нь үүсгэчихье.

Ч.Цогтбаатар: Ус ашигласан тухай мэдээлэл байна. Үүнд хэдэн хувь нь эргэлтийн ус байна вэ гэдэг мэдээллийг оруулчихвал нийт усны хэдэн хувийг буцааж ашиглаж байгааг мэдэх боломжтой юм. Мөн усны төлбөрт хэдэн төгрөг төлж байна гэсэн үзүүлэлтийг нэмээд оруулчихмаар байна. Үүнээс гадна эрчим хүч, түлш шатахууны хэрэглээний талаар оруулж болдог болов уу? хэрвээ оруулж болдог бол хэрэгтэй мэдээлэл болох юм. Эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй байгаа, ОХУ болон Хятад улсаас импортолж байгаа, цахилгаан станцууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа, ялангуяа зүүн бүсийн станцууд доголдолтой ажиллаж үйлдвэрлэлийнхээ 30-40 хувийг алдаад байдаг. Иймд эрчим хүч түлш шатахууны хэрэглээний асуудлыг оруулвал яах бол гэсэн санаа байна.

Ж.Батцэнгэл: Татвартай холбоотой мэдээллийг шинээр оруулах гэсэн байна. Манай байгууллагаас гаргаж байгаа мэдээллээ холбоос болгож оруулж болно гэхдээ татварын тайлан мэдээлэл байнга өөрчлөгдөж байдаг. Оруулсан мэдээллийг нэг хүн татаж аваад судалгаа шинжилгээний ажил хийж байтал нөгөө мэдээлэл өөрчлөгдөх тохиолдол гарч болно. Санхүүгийн тайланд аудитын дүгнэлт хийлгэсэн нөхцөлд тайланд өөрчлөлт ордог, орлого зардлаа буруу дансаар тайлагнасан тохиолдол, шүүх цагдаагаар асуудал шийдэгдэх зэрэг нөхцөл байдлын улмаас компанийн санхүүгийн тайланд өөрчлөлт засвар ордог. Ингэж тайлан өөрчлөгдсөн тохиолдолд татвар төлөлт дээшээ доошоо болно. Шинэ хуулиар татварын газартай гэрээ хийсний үндсэн дээр илүү дутуугаа бусад үүсвэрээс нөхөх зэрэг шинэлэг боломжууд гарч байгаа. Иймд манай татварын ерөнхий газрын холбоосоор дамжуулан мэдээллийг оруулахыг түдгэлзүүлж өгөхийг хүсэж байна. Манай мэдээллийг холбосноор бүрэн дүүрэн мэдээлэл авах, чанарын хувьд хангалттай биш байх болов уу. Компанийн төлөөлөл бас саналаа хэлэх байх. Борлуулалт гээд нэг дүн оруулчихдаг түүнийг хүдэр уран гэх мэт бүтээгдхүүнээр салгахгүй бол хангалттай мэдээлэл болж чадахгүй байх гэсэн болгоомжлол байна.

Ш.Цолмон: Татварын алба дийлэнх орлогыг ил тод болгож байгаа. Орлогын хувьд өөрчлөлт гарвал манай аудитийн компаниуд нягталж тохируулгыг хийдэг. Иймээс компанийн тайланд тохируулгын дараах байдлыг оруулснаар өөрчлөгдсөн мэдээллийг ил тод харах боломжтой болдог. Тэр утгаар болох байх гэж ойлгож байгаа. Хүмүүс мэдээллийн том дүнг сонирхож харахаас биш зөрүүг нэг их сонирхож харахгүй болов уу, зөрүүг холбогдох мэргэжилтнүүд тодруулаад тохируулга хийх боломжтой гэдэг үүднээс болох байх гэж харж байна. Гишүүд саналаа өгөх байх.

Л.Бор: Хавсралтын 4.1.3 дотроо орчихоод байна, цацраг идэвхит бодисын талаарх мэдээллийг тусад нь оруулж болох уу? энэ нууцлалын зэрэгт байдаг мэдээлэл юм. Цацраг идэвхит бодисын ашиглалтын зөвшөөрөл компани 9 байдаг

эдгээр нь ямар бүтээгдхүүн гаргаж, үйлдвэрлэж байгаа талаар мэдээлэл байдаггүй.

Ш.Цолмон: Улсын нууц энэ тэр талаар сайн мэдэхгүй байна.

Ч.Цогтбаатар:Маягтад ашигт малтмалын төрөл гээд байхад түүнд ямар төрлийн ашигт малтмал гэдгээ бичих боломжтой харагдаж байна, заавал уран гээд ялгаад байх шаардлагагүй байх гэж бодож байна. Одоо уран ашиглаад байгаа юм байхгүй, ганц туршилтын үйлдвэр явуулах гээд тэр нь сайн ажиллаж чадахгүй байгаа.

Д.Цэрэнпүрэв: Компанийн засаглалыг ил тод болгох үүднээс хандивын мэдээллийг оруулах санал байна. Иргэд рүү чиглэсэн мэдээлэл бага харагдаад байна.

Ш.Цолмон: Хандивын талаарх мэдээлэл компанийн тайланд байгаа, энэ бол өмнөх авч байсан мэдээлэл дээр нэмж оруулах юм.

Б.Баярмаа: Энэ ажилтан ажилчдын мэдээллийг бүх уул уурхайн компаниуд гаргана биз дээ. Удирдах ажилтнууд гэдэгт хэн хэн орох вэ түүнийгээ жаахан задламаар байна. Гэрээний талаарх мэдээлэл гэдэгт хүний нэр бичих үү, ер нь бол орон нутгийн засаг захиргаатай буюу засаг даргатай компаниуд гэрээ байгуулж байгаа. Энэ мэдээлэл тийм ач холбогдолтой юу? Гэрээний зорилго агуулга гэдэгт ерөнхий урт юм байдаг үүнийг бичнэ гэсэн үг үү? Гэрээ нь хуульд заасан гурван нөхцлийг хангах үүднээс хийгдсэн байдаг харин зарим томоохон гэрээ тухайлбал Оюутолгойн гэрээн дээр орон нутгийн хөгжлийн санд жилдээ 5 сая доллар өгнө гэсэн онцлог заалт байдаг. Үүн шиг онцлог заалттай гэрээнүүдийн мэдээллийг оруулаад түүндээ хяналт хийвэл илүү ач холбогдолтой болов уу. Хамтын ажиллагааны хорооны бүрэлдхүүн гэдэгт ямар мэдээлэл авах юм бэ? бүрэлдхүүн юм уу? тоо юм уу? Үүнийгээ гурав хуваагаад гурван талын тэнцүү оролцоо байна уу гэдгээ харвал зүгээр байна.

Ш.Цолмон: Мэдээллийг бүх компаниуд гаргана. Ерөнхийдөө гишүүдийн тоог авах юм.

Б.Баярмаа: Үүнийгээ гурав хуваагаад гурван талын тэнцүү оролцоо байна уу гэдгээ харвал зүгээр гэсэн санал байна. Мөн ус ашигласны мэдээлэлд ус бохирдуулсны төлбөр орох уу, одоо Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжиж байгаа. Хэрвээ ус бохирдуулсны төлбөр төлвөл энэ тайланд орж таарна, энэ нь нилээн их төлбөр орж ирэхээр байгаа. Хуулийг дагалдаж гарах журмууд нь батлагдсан одоо хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр магадгүй ус бохирдуулсны төлбөр, стандартаас илүү хэмжээгээр ус бохирдуулсны төлбөр гээд төлбөрүүд шинээр орж ирнэ мөн бохирдуулсан усны хэмжээний мэдээлэл орох байх. Ашиглах усны хэмжээг дүгнэлтээр гаргуулсан байх ёстой байдаг. Дүгнэлт хийлгэсэн байна уу, зөвшөөрөл байна уу, дүгнэлтээр заагдсан усыг ашиглаж байна уу зэрэг хоорондоо уялдаатай асуудлууд байдаг. Зөвшөөрөл нь хэрэглээний зориулалттай зөвшөөрөл байна уу, үйлдвэрлэлийн зориулалттай зөвшөөрөл байна уу гэдэг ялгаатай. Зарим компаниуд хэрэглээний зориулалттай зөвшөөрөл авчихаад үйлдвэрлэлд ашиглаад байдаг. Иймд уул уурхайн салбарт ашиглаж байгаа усны асуудал чухал болоод байгаа. Хэрэглэж байгаа усны хэмжээний талаарх мэдээлэл байхгүй байна, ашигласны хэмжээгээр төлбөр байна зэрэг асуудлууд байна. Үүнээс болоод орон нутгийн иргэд, компани иргэний нийгмийн хооронд зөрчил

маргаан гарч байна, цаашдаа ч ус багасаж байгаа учраас үргэлжилнэ. Тэгэхээр ус ашигласны мэдээллийг дээрх хуультай нийцүүлээд, жаахан дэлгэрүүлж оруулах саналтай байна.

н.Баяраа: Нэмэлт мэдээлэлд туслан гүйцэтгэх компаниудын талаарх мэдээллийг оруулмаар байна. Үндсэн компани нь цөөхөн ажилтантай байсан ч туслан гүйцэтгэх нь түүнээс олон ажилтантай, өндөр орлоготой байдаг. Туслан гүйцэтгэх компаниудтай ямар гэрээ хийсэн, хэдий хэмжээний зардал гаргасан талаарх мэдээллийг оруулах нь зөв байх, жишээ нь Оюутолгой компани гэхэд 700 гаруй туслан гүйцэтгэх компанитай гэрээтэй ажилладаг гэдэг. Усны асуудлын талаар хэрэглэсэн усны хэмжээг мэдэхгүй гэж яриад байна. Үйлдвэрийн хэрэглэсэн ус нь тодорхой байдаг, заавал тэдий хэмжээний ус ашигласан гэж компани өөрөө мэдүүлэх биш тэдий хэмжээний хүчин чадалтай тоног төхөөрөмж ажиллуулахад тийм хэмжээний ус ашиглана гэдгийг захын хүн тооцоолоод гаргах боломжтой. Зарим нь ашигласан усны хэмжээг нуух, тоолуураа ашиглахгүй байх зэрэг асуудал гаргадаг. Задгай хэрэглэж байгаа газруудын тооцох жишиг гаргах боломжтой байх гэж бодож байна.

Н.Баярсайхан: 2019 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хэдэн хувийн биелэлттэй гэж үзэж байна. Тогтоолын төсөлд оруулахын тулд хувилсан нь зөв байх гэсэн саналтай байна. 2020 оны ажлын төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа. 2018 оны нэгтгэл тайланд БДО аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар 2020 оны төлөвлөгөөндөө оруулах хэрэгтэй байх. Тэнд зөвлөмж өгөөд байдаг бид тусдаа төлөвлөгөө хийгээд байвал энэ зөвлөмж хэрэгжихгүй болно, үүнийг тусгаж ажлын төлөвлөгөөгөе сайжруулах хэрэгтэй байна. Аудитын зөвлөмжид дэд зөвлөлийг чадавхжуулах талаар дурдлаа, бид дэд зөвлөлийг чадавхжуулахгүйгээр жилдээ нэг хоёр удаа хуралдаад ОУИТБС маань цаашаа явахгүй байна. Ерөнхий сайдын түвшинд байснаа Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны түвшинд ирж байна. УУХҮЯ, БОАЖЯ ижил түвшиний статустай байгууллагууд хэн нь хэнийгээ даргалах юм? Иймд бид орон нутагт байгаа аймаг, сумдын дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгож ажиллах санал байна. Бид 2017 онд Дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгож ажилласан ч тухайн цаг үед хөрөнгө санхүүжилт байхгүйн улмаас юу ч хийж чадаагүй. Иймд 2020 оны төлөвлөгөөг Дэд зөвлөлд чиглэсэн ажил хийхээр төлөвлөж, төлөвлөгөөг яг юун дээр фокуслах, ямар үр дүнд хүрсэн байх вэ гэдгийг тодорхой болговол илүү үр дүнтэй байна гэсэн санал байна. 2019 оны төлөвлөгөөний биелэлт болон 2020 оны төлөвлөгөөний төсөлд гишүүдийн оруулсан саналыг тусгаж нэгтгээд нэг шийдвэр гаргах саналтай байна. Төлөвлөгөө ажлын хэсгийн гишүүдэд явуулаад 12 сарын 15-ны дотор саналыг нь авч нэгтгээд Үндэсний зөвлөлөөр батлавал арай бодитой болох байх. Маягтад оруулах саналаа ТАН эвслийн зүгээс хүргүүлсэн байгаа, энд ороогүй байна, түүнийг эргэж хараарай. Мөн маягтын 4.1.1-д байгаа удирдах зөвлөлийн мэдээлэлд гишүүдийн нэрийг авахаас гадна сард хэдэн төгрөгийн урамшуулал авдаг талаарх мэдээллийг оруулмаар байна. Баярлалаа.

Ш.Цолмон: Болно оо, ЕСБХБ-ны үлдэгдэл санхүүжилт орж ирэх найдвар байгаа энэ үед хэдэн ажил хийгдэхээр төлөвлөсөн байгаа. Ингэвэл төлөвлөгөөний биелэлт арай гайгүй болох юм. ТАН эвслийн санал аудитор руу явсан байгаа, бид эргэж харъя, өөрчлөлтийг нэмж боловсруулаад та бүхэнд тараая.

Н.Баярсайхан: Бид өгсөн саналаа илүү тодотгоод өгье. Жишээлбэл, орон нутагтай хийсэн гэрээн дээр тухай гэрээ нь сантай юу? Өөрөөр хэлбэл гэрээний

хүрээнд сан байгуулахаар зохицуулсан уу гэдгийг баганаар нэмж оруулмаар байгаа. Энэ мэтээр өгсөн саналаа илүү тодотгоод өгье гэсэн санал байна.

Л.Бор: Жендерийн мэдээлэл гэдэгт яг юу орох вэ?

Ш.Цолмон: удирдлага болон бусад мэдээлэл байх болов уу?

Баяраа: Мэдээллийг яамны сайтад байршуулна гээд байна, энэ нь олон нийтэд мэдээлэл өгөх гээд байна уу үгүй юу гэдэг нь тодорхойгүй харагдаад байна, яагаад гэвэл тэр сайтад ордог хүн нь хэд билээ, ингэхээр хүртээмж бага болно. Тэгэхээр олон нийтэд мэдээллийг арай өөр хэлбэрээр хүргэх арга оруулмаар байна, яамны сайтад тавих шиг амархан юм байхгүй.

Н.Баярсайхан: Яамдуудаас ил болгох мэдээллийн талаар санал авсан уу? яамдууд бэлэн байна уу боломжтой юу гэдгийг тодруулах хэрэгтэй байна. БОАЖЯ-наас шинээр оруулах хоёр төрлийн мэдээлэл байна. Үүнд химийн бодисын талаарх мэдээллийг оруулмаар байна. Жилдаа ямар төрлийн хэдийн хэмжээний мэдээлэл авч байна, яаж хэрэглэж байгаа талаарх мэдээлэл зайлшгүй баймаар байна. Үндэсний аудитын газрын мэдээлэлд хяналт хийсэн санхүүгийн үйл ажиллагааны талаарх тайлан, дүн мэдээ гэж оруулмаар байна. ТЕГ-аас татвараа хугацаандаа төлөөгүй аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээлэл гарч болох уу?

Ж.Батцэнгэл: тийм мэдээлэл тусдаа гарах боломжгүй, манай тайлангаар гараагүй л бол төлөөгүй гэсэн үг. Ямар шалтгаанаар яагаад төлөөгүй гэдгийг мэдэх арга байхгүй.

Н.Баярсайхан: Улсын бүртгэлийн газрын гаргах мэдээлэлд Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч жинхэнэ өмчлөгийн мэдээлэл гэдэгт бидний яриад байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг хэлж байна уу, туслан гүйцэтгэх компаниуд орох уу? аж ахуйн нэгж гэхээр бүгд орох юм шиг харагдаад байна, эхний ээлжинд тусгай зөвшөөрөл эзэмшигч гэж явах уу нэг шийд гаргамаар байна. Ашигт малтмал газрын тосны бүтээгдхүүний сар бүрийн мэдээ гэдэгт химийн бодисын талаарх мэдээг оруулах нь зөв байх. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын гаргах мэдээлэлд хайгуулын барьцаа хөрөнгийн талаарх мэдээллийг аймгууд гаргаж өгдөг байхаар оруулах нь зүйтэй, үүнийг нэмэх саналтай байна. Сан Дорноговийн хөгжил сан, Говийн Оюу сан, Хөшөөт сан зэрэг сангуудын мэдээллийг аймагтаа ил тод нээлттэй болгох талаар аймаг нийслэлийн Засаг дарга, Тамгын газрын мэдээлэлд оруулж өгөх саналтай байна. ТӨК-уудын мэдээлэл хаалттай хэвээр байна. Жишээ нь, Эрдэнэс таван толгой компани нүүрс зөөх тендерийг хэрхэн явуулж, шалгаруулсан бэ? уг нь тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулалт нь явах ёстой. Энэ мэдээлэл ил байдаггүй учраас борлуулалтын гэрээ, ялсан компанийн мэдээллийг ил болгохоор оруулвал зүгээр байна. Мөн ТӨК-ууд ханган нийлүүлэлтийн компанийн нэрийг ил болгох хэрэгтэй түүнчлэн экспортын гэрээг ил болгох талаар үүрэг болговол бусад компаниудад манлайлал үзүүлэх ач холбогдолтой юм.

Ч.Цогтбаатар: Гишүүдийн хэлсэн саналыг тусгаж оруулахыг Ажлын албанд даалгая. Засгийн газрын тогтоолын төсөл дэмжигдвэл Үндэсний зөвлөлийн хуралд оруулж батлуулсны дараа бүх яамдаас санал авна. Тухайн үед эдгээр мэдээллийг гаргах боломжтой гэх үү, үгүй гэдгийг мэдэхгүй, яамдаас авсан саналыг нэгтгэж, Засгийн газрын хуралдаанд оруулж, хэлэлцүүлж тогтоол гаргуулах ёстой. Ер нь

тийм ч мэдээлэл хэрэгтэй байна, ийм ч мэдээлэл хэрэгтэй байна гээд ухаад байвал мэдээлэл дуусахгүй. Тийм учраас ОУИТБС-ын олон улсын стандартаа баримтлах нь зөв байх, түүнд нийцсэн мэдээллээ бэлтгэх байдлаар ажиллах нь зүйтэй байх.

Хурал даргалагч Хуралдааны шийдвэрийн төслийг уншиж танилцуулан санал хураав. Гишүүдийн олонхи дэмжсэнээр шийдвэрийг баталлаа.

Ч.Цогтбаатар: Өнөөдрийн хуралдаан амжилттай болж өндөрлөлөө. Гишүүд та бүхнийг идэвхтэй оролцож, санал дүгнэлт өгсөнд баярлалаа. Төлөвлөгөө болон нэмэлт мэдээллийн маягтад оруулах саналаа цахимаар идэвхтэй өгөөрэй.

2019 онд хөрөнгө мөнгөгүйн улмаас зарим ажлууд цалгардсан хэдий ч Ажлын алба сайн ажилласан гэдгийг тэмдэглэн хэлмээр байна. 2019 оны ажлаа амжилт бүтээлээр дүүрэн үдэж, ирэх 2020 ондоо амжилттай сайн ажиллаарай гэж ерөөе. Та бүхэнд баярлалаа.

Хурал 14.45 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,
ОУИТБС-ын ажлын хэсгийн ахлагч



Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:
УУХҮЯ-ны Стратеги бодлого,
төлөвлөлтийн газрын ахлах шинжээч:



Ч.Цогтбаатар

Тэмдэглэлийн хянасан:
ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны
Санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг